



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТҮР ХОРООНЫ
ТОГТООЛ**

2023 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 06

Улванбаатар хот

**Монгол Улсын Засгийн газарт
чиглэл өгөх тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.14 дэх заалт, 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсгийг үндэслэн Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, чанар, аюулгүй байдлыг хангах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих асуудлаар холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг судалж, санал боловсруулах, дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулах үүрэг бүхий Түр хорооноос ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" 36 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т чиглэл болгосугай:

Нэг. Эрх зүй, санхүү, төсвийн чиглэлээр:

1/хүнсний хангамж, аюулгүй байдал, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих асуудлыг шийдвэрлэх зорилгоор Төрийн албаны тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль болон бусад холбогдох хуулиудад өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, 2023 оны эхний хагас жилд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

2/Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолд тусгагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг 2023 оны нэгдүгээр улиралд багтаан бүрэн шийдвэрлэх, санхүүжилтийг олгохдоо Монгол Улсын хөгжлийн бодлого, эдийн засгийн төрөлжилт, бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан газар зүйн байршил, кластерын тогтолцоо, бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар, зах зээлийн багтаамжийг харгалзан үзэх;

3/хүнсний хангамж, аюулгүй байдал, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих бодлогын зээлийг бизнесийн онцлог, бүтээгдэхүүний төрлөөс хамааруулан зээлдэгчийн төлөх хүүг 3.0-5.0 хувь байхаар тооцож, нийт зээлийн 30-аас доошгүй хувийг хөдөө аж ахуйн үйлдвэрлэл шинээр эрхэлж байгаа болон жижиг, дунд бизнес эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж үйл ажиллагаагаа өргөтгөхөд, 10-аас доошгүй хувийг импортыг орлох, экспортод чиглэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төслүүдэд гүйцэтгэлтэй нь уялдуулан үе шаттайгаар санхүүжилт олгох, мөн Засгийн газрын хариуцан төлөх зээлийн хүүг эдийн засгийн нөхцөл, Монголбанкны бодлогын хүүтэй уялдуулан тогтоож, шаардагдах санхүүжилтийг жил бүр улсын төсөвт тусгах;

4/хүнс, хөдөө аж ахуйн салбарын хүний нөөцийг бэлтгэх, сургах, давтан сургах, мэргэшүүлэх, дадлагажуулах төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх;

5/"Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл (Нэмэлт санхүүжилт-2)", "Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төсөл"-ийн 2 дахь шат, "Цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох чадвартай мал аж ахуй", "Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөрөнгө оруулалтын хөтөлбөр" зэрэг гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэх төслүүдийг яаралтай эхлүүлэх;

6/хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хэрэгжүүлж байгаа болон шинээр хэрэгжүүлэх төслүүдийн санхүүжилтийг Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолд тусгагдсан үйл ажиллагаатай уялдуулан санхүүжүүлж, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлж ажиллах;

7/хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай шинэ техник, тоног төхөөрөмжийг худалдан авахад хөнгөлөлттэй санхүүжилт болон гааль, татварын бодлогоор дэмжих.

Хоёр.Мал аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэлээр:

1/мал аж ахуйн үйлдвэрлэлд дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэн, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, боловсруулалтын түвшнийг ахиулах, маркетинг, өртгийн сүлжээг хөгжүүлж зах зээлд өрсөлдөх чадвар, бүтээмжийг нэмэгдүүлэх "Мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийн стратеги" боловсруулж батлуулах;

2/мал сүргийг бүртгэлжүүлэх, ашиг шимийг хянан баталгаажуулах, стандартын шаардлага хангасан үржлийн малыг тусгайлан тогтоосон бүс байршилд үржүүлэх, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх төлөвлөгөө, зураглалыг тодотгож, гахай, тахиа, зөгий, загасны аж ахуйд хөрөнгийн дэмжлэг үзүүлэх;

3/бэлчээр ашиглалт, хамгаалалтын менежментийг сайжруулах, хадлан, гар тэжээл бэлтгэх, тэжээлийн таримлын тариалалтыг нэмэгдүүлэхэд шаардлагатай үр, бордоо, техник, тоног төхөөрөмжийн хангамжийг бүрдүүлэх, малын төрөл, ашиг шимийн үзүүлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн тэжээл үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд бодлого, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

4/мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх үндэсний аяныг зарлаж, удирдлага зохион байгуулалт, хөрөнгө санхүүгийн асуудлыг шийдвэрлэх, мөн эрүүл бүсийг байгуулах, био бэлдмэлийн дэвшилтэт технологи нэвтрүүлэх, Биокомбинатын үйл ажиллагааг өргөтгөн шинэчлэх, вакцины хүйтэн хэлхээний сүлжээг бий болгох зэрэг ажлуудын санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой болгох.

Гурав.Газар тариалангийн үйлдвэрлэлийн чиглэлээр:

1/төмс, хүнсний ногооны техник, бордоо худалдан авахад үнийн дүнгийн 50 хүртэлх хувьд хөнгөлөлт, дэмжлэг олгох, тариалангийн талбайг хашаажуулахад шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх асуудлыг судалж, холбогдох арга хэмжээ авч ажиллах;

2/"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжүүдийг газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж

ахуйн нэгжтэй хамтарч тариалангийн талбайд ойн зурвас байгуулахад бодлогын дэмжлэг үзүүлэх;

3/үр үйлдвэрлэл, үрийн технологийн нөөц бүрдүүлэх, төмс, хүнсний ногооны агуулахын аж ахуй, зоорь байгуулах, тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэхэд урамшуулал олгох, хүлэмжийн аж ахуйд хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх, мөн говийн бүсэд хүлэмжийн аж ахуйг түлхүү хөгжүүлэх;

4/нийслэл, орон нутагт төмс, хүнсний ногооны хадгалалт, борлуулалтын логистик сүлжээг зохион байгуулж ажиллах;

Дөрөв.Хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр:

1/хөгжлийн бодлого, төлөвлөлт болон бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан бүс нутгийн онцлог, нөөц боломжид тулгуурлан кластрын зохион байгуулалттай, зах зээлд өрсөлдөх чадвартай, салбар хоорондын уялдааг хангасан хүнсний чиглэлийн үйлдвэрлэл, худалдааны нэгдсэн тогтолцоо, кластерын сүлжээг бүрдүүлэх;

2/Хүнсний эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэнг байгуулах асуудлыг судалж, шийдвэрлэх;

3/хүнс, хөдөө аж ахуйн салбарын цахим системүүдийг уялдуулан хүнсний хангамж, аюулгүй байдлыг хянах нэгдсэн цахим системийг бий болгох.

2.Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэн, дотоодын болон олон улсын санхүүгийн байгууллага, хөгжлийн түнш байгууллагуудтай хамтран санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх талаар холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Монголбанкны Ерөнхийлөгч (Б.Лхагвасүрэн)-д зөвлөсүгэй.

3.Энэ тогтоолын биелэлтийг 2023 оны хаврын чуулганы хугацаанд Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороонд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ХҮНСНИЙ ХАНГАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ,
ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ,
ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ
ДЭМЖИХ АСУУДЛААР ХОЛБОГДОХ
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ
СУДАЛЖ, САНАЛ БОЛОВСРУУЛАХ ҮҮРЭГ
БҮХИЙ ТҮР ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ